



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Ажилтан сонгон шалгаруулж авах
журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.15, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн “Ажилтан сонгон шалгаруулж авах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны А/06 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.
4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ



Амгалан Дулааны станц ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны
өдрийн 1/20 дугаар тушаалын хавсралт

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НД АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВАХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажлын байрны шаардлага хангасан иргэнийг ажилд сонгон шалгаруулж, хүний нөөцийг бэлтгэхэд оршино.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 71 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Амгалан дулааны станц ТӨХК-ийн дүрмийн 9.9.8-д “...Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан ажилтныг томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх, ажлын байрны тодорхойлолт, тариф мэргэжлийн лавлахыг батлах, мөрдүүлэх аливаа ажлын хэсэг, комисс томилон ажиллуулах...” гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “..Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох...” гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү журмыг батлав.

ГУРАВ. АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЕ ШАТ

3.1. Ажил горилогч нь тус байгууллагад шаардлагатай мэргэжил боловсрол эзэмшсэн, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна. Шаардлагатай бол мэргэжлийн өндөр ур чадвартай гадаадын иргэнийг шууд гэрээний үндсэн дээр ажиллуулах болно.

3.2. Амгалан дулааны станцад ажилд орох хүсэлтээ гаргасан иргэдээс мэргэжлийн ерөнхий мэдлэг, хөдөлмөр эрхлэх сэтгэл зүйн бэлтгэл хангагдсан эсэх талаар Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Хүний нөөцийн менежер, нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнтэй шалгаруулалт явуулна. Шаардлагатай бол ажил үүрэг гүйцэтгүүлэх шалгаруулалт явуулна.

3.3. Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвд илгээх эрүүл мэндийн үзлэгийн хуудас олгоно.

3.4. Эрүүл мэндийн хувьд тэнцэх дүгнэлт гарсан иргэн компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.2 дахь заалтанд тусгасан баримт бичгийг бүрдүүлнэ.

3.5. Иргэнийг ажилд авах тухай Гүйцэтгэх захирлын тушаал гарна.

3.6. Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

3.7. Шинэ ажилтныг ХАБЭА-н урьдчилсан болон анхан шатны ажлын байрны зааварчилгаанд хамруулна.

3.8. Шинээр ажилд орж буй ажилтанд Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм, компанийн сургалт хөгжлийн журманд заагдсан сургалтуудад хамруулна.

3.9. Тариф мэргэжлийн лавлах мөрдөн ажилладаг ажилтан дагалдан сурах хугацаандаа компанийн мэдлэгийн шалгалтын комисст шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд Гүйцэтгэх захирлын тушаалаар мэргэжлийн зэрэг олгох буюу жинхэлж, хөдөлмөрийн гэрээ байгуулна.

3.10. Мэргэжлийн зэрэг авсан ажилтныг Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн дагуу хариуцлагатай дагалдуулан сургана.